

**УЛААНБААТАР ХОТ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
20-Р ХОРООНД БАЙРЛАХ “ГАЗРЫН ТОСНЫ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ” ТӨСЛИЙН
2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Гарчиг

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн хүчин чадал.....	4
1.2. Төслийн ерөнхий төлөвлөлт	4
1.3. Технологийн үйл ажиллагаа	6
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
2.1. Төсөл хэрэгжих байршил	9
2.2. Төслийн физик газарзүй.....	10
2.3. Цаг уур, уур амьсгал.....	10
2.4. Хөрсөн бүрхэвч.....	11
2.5. Гадаргын ус.....	12
2.6. Ургамал бүрхэвч	13
2.7. Нийгэм эдийн засаг	15
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	16
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	17
5. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
5.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	19
5.3. Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө	20
5.4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	21
5.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
5.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24
5.7. Тухайн жилийн БОМТ-ийн хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	25

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. 2023 оны БОМТ-ний нийт зардал	17
Хүснэгт 2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	18
Хүснэгт 3. Орчны тохижилт хийх төлөвлөгөө	19
Хүснэгт 4. Осол, эрсдэлийн төлөвлөгөө	20
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 6. ОХШХ	23
Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24
Хүснэгт 8. БОМТ тайлагнах хуваарь	25

Зургийн жагсаалт

Зураг 1. Технологийн схем.....	Error! Bookmark not defined.
Зураг 2. Төсөл хэрэгжих байршил	9
Зураг 3. Хөрсний хэв шинж, хороогоор	Error! Bookmark not defined.
Зураг 4. Ургамлын хэв шинж, хороогоор	Error! Bookmark not defined.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	Газрын тосны бүтээгдэхүүний агуулах
Төсөл хэрэгжүүлэгч:	“ШИНЭ ШАНД” ХХК
Төсөл хэрэгжүүлэх улсын бүртгэлийн дугаар:	000192635
Төсөл хэрэгжүүлэгчийн регистрийн дугаар:	6252281
Нэгж талбарын дугаар:	1801501007
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Аюуд тауэр, 1405 тоот
Утас:	77114144, 88548088
Газар ашиглах хэлбэр:	Эзэмших
Газрын зориулалт:	Агуулах, агуулахын байгууламж
Газрын хэмжээ:	21406 м.кв = 2.14 га

1.1. Төслийн хүчин чадал

Төслийн зорилго: Газрын тосны бүтээгдэхүүний агуулах нь бүтээгдэхүүн хүлээн авч, нөөцлөн хадгалж, гэрээт компаниудад хүлээлгэн өгөх, дотоодын хэрэгцээг хангах зорилготой.

Төслийн үйл ажиллагаа: “Таван толгой түлш” компанийн Нүүрсний газрын урд 1.3 км зайд байрлах тухайн төслийн талбайг “Агуулах, агуулахын байгууламж”-ын зориулалтаар 2024 оны 5-р сард 15 жилийн хугацаатай, эзэмших эрхтэйгээр авсан ба “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” хэлбэрээр ашиглахаар ажиллаж байна. Өмнө нь уг талбайд Шинэ шанд ХХК нь аж ахуйн зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг байсан.


1.2. Төслийн ерөнхий төлөвлөлт

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэхэд ашиглах үндсэн байгууламжийн хэмжээ, хүчин чадал

№	Барилга байгууламжийн нэр	Тоо	Хэмжээ, хэмжих нэгж
1	Оффисын барилга 24.0х12.0	1ш	288 м ²
2	Насос станц 12.0х21		252 м ²
3	Босоо цилиндр ил сав	3ш	2000м ³
4	Босоо цилиндр ил сав	2ш	3000м ³
5	Хэвтээ цилиндр суллах сав	5ш	10м ³
6	Галын усан сан	1ш	500м ³
7	Галын хана		
8	Ачаа шалгах шат тавцан		
9	Автоцистернд ачих төхөөрөмжийн шат тавцан, саравч		
10	10 байраар вагонцистернээс шатахуун буулгах төхөөрөмж, түүний шат тавцан эстакад		
11	Автоцистернд ачих төхөөрөмжийн бетон талбай		
12	Автоцистернээс шатахуун буулгах бетон талбай		
13	Ачаа шалгах бетон талбай		
14	Сав паркны бетон талбай		
15	Автомашин хөдөлгөөний зам талбай		
16	Галын автомашин, техник хэрэгслийн зам талбай		
17	Аянга хамгаалагч	2ш	
18	Гэрэлтүүлгийн цамхаг	2ш	
19	Галын багажны сарай	2ш	
20	Автоцистернээс шатахуун буулгах худаг		

**“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” төслийн
2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

21	Ууршуулах талбай		
22	Дизель цахилгаан үүсгүүрийн байр		
23	Харуулын байр 3.0х3.0м	2ш	
24	Бохирын цооног		
25	Хаалга		
26	Авто зогсоол		
27	Асфальтан авто зам		4646м ²
28	Хайрган авто зам		1311м ²
29	Явган хүний зам		300м ²
30	Төмөр зам		
31	Ногоон байгууламж		4917м ² буюу 25%



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт, план

Техникийн тоо хэмжээ, хүчин чадал: Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах нийт багтаамж нь 10000-12000м³ бөгөөд IIIа зэрэглэлийн агуулах юм.

Төслийн талбайд газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалттай 2000м³ босоо цилиндр сав 3ш, 3000м³ багтаамжтай босоо цилиндр сав 2ш байна. Бүтээгдэхүүн хадгалах савыг ган материалаар хийх ба хөдөлдөггүй дээвэр, хлопшука төлөвлөж, зэврэлтээс хамгаалсан байна.

Төслийн талбайд дээрх байгууламжуудаас гадна төмөр зам, ачих төхөөрөмж, саравч, харуулын байр, галын усан сан, авто машины зам талбай, галын сарай, аянга зайлуулагч зэргийг төлөвлөсөн.

Боловсон хүчин: Төслийн талбайд инженер-2, эрхлэгч-1, ХАБЭ ажилтан-2 цахилгаанчин-2, ачигч, засварчин-4, санхүү хариуцсан менежер-1, тогооч-2, үйлчлэгч-2, нийт 16 хүн ажиллана.

1.3. Технологийн үйл ажиллагаа

Шатахуун ачилт, буулгалт (Вагонцистерн, автоцистерн): Бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэн нийлүүлж, вагонцистерн болон автоцистернд ачна. Вагонцистерн сард 23000м³ шатахуун хүлээн авч, 25000м³ бүтээгдэхүүнийг автоцистернд ачна. Төслийн талбайд 160 м урттай төмөр зам байх ба буулгах, ачих гар нь бүтээгдэхүүний төрөл хамаарахгүй байр бүрд дундаа нэг байна. Үүнд доогуур буулгах болон ачих байр-10, дээгүүр буулгах байр-1, дээгүүр ачих байр-1 байх юм.

Хүснэгт 2. Шатахуун ачилт, буулгалт (вагонцистерн, автоцистерн)-ын хүчин чадал

Вагоцистернээс шатахуун буулгалт/ачилт	
Бүтээгдэхүүн төмөр замаар тээвэрлэгдэн нийлүүлэгдэнэ. Мөн вагоцистернд ачна.	Нэг сард ойролцоогоор 23000м ³ шатахуун хүлээн авна.
Нэгэн зэрэг төмөр замаар буулгах/ачих байрлал (Буулгах/ачих гар нь бүтээгдэхүүний төрөл хамаарахгүй байр бүрт дундаа нэг байна.)	Доогуур буулгах/ачих байр-10 Дээгүүр буулгах байр-1 Дээгүүр ачих байр-1
Нэг вагонцистерны эзлэхүүн/багтаамж	80м ³
Нэг удаад хүлээн авах вагонцистерны хамгийн их тоо	10
10 вагонцистерн зэрэг буулгах багтаамж	800м ³
Буулгах хүчин чадал	160м ³ /цаг (насосны чадлаар)
10 вагонцистерн орлогыг буулгах хугацаа	7 цаг (буулгах 5-, сэлгээ 2ц)
Нэг өдрийн ажлын 10 цагийн үргэлжлэх хугацаанд	1143м ³
Ажлын 20 хоногт буулгах нийт хэмжээ	22860м ³
Бүтэн сар зогсолтгүй ажиллахад онолын нийт хэмжээ	34290м ³
Хийн буцаах систем	төлөвлөхгүй
Хэмжих хэрэгслээс буулгах /вагонцистернээс буулгах/	Тоолуур төлөвлөхгүй. Вагонцистерны эзлэхүүнийг тооцоолсон онооны хүснэгтийг хэрэглэх хэмжилтийн системийг ашиглана.
Вагонцистернээс доогуур буулгах гар	Нугасан үетэй, PN16, тулгуур баганатай, орос вагонцистерны хүйстэй холбогдох амтай байна
Вагонцистернээс доогуур буулгах байгууламжийн шат тавцан	10 вагонцистернд зэрэг гарах нэгдсэн шат
Автоцистернд шатахуун ачилт	
Бүтээгдэхүүнийг ачиж түгээнэ	Нэг сард ачиж, түгээлт хийх төлөвлөгдсөн хэмжээ 25000м ³
Нэгэн зэрэг автоцистернд ачих байрлал	Дээгүүр ачих байр-5 (нэг арлын 2 талд өөр өөр бүтээгдэхүүн ачна)
Дээгүүр ачих	P-92
Арал #1 дээр Ачих байр #1	ДТ, ЕД
Арал #2 дээр Ачих байр #3,4	Кер, Кер
Арал #3 дээр Ачих байр #5,6	
Нэг автоцистерны эзлэхүүн/багтаамж	40тн (түлш 45, бензин 53м ³)
Нэг ачих гар дээр зарцуулга	1500л/мин (90м ³ /цаг насос)

Нэг өдрийн ажил үргэлжлэх хугацаа	10 цаг
Ачилтын гар бүр дээр нэг өдөрт ачих автоцистерны тоо	40 мин (ачилт25+сэлгээ15)
6 ачих гараар нэг өдөрт ачих хамгийн их автоцистерн	15
Нэг өдөрт ачих хамгийн их хэмжээ	90
Ажлын 20 хоногт ачих нийт хэмжээ	4260м3
Бүтэн сар ажиллахад онолын нийт хэмжээ	85200м3
Хийн буцаах систем	127800м3
Байр бүрд	Төлөвлөхгүй
Автоцистернд ачилтын систем	Ачих гар, шатахууны тоолуур, шүүлтүүр, газардуулгын холбогч төлөвлөнө
Автоцистернд ачилтын тоолуур	Ачилтын систем нь температурын тэнцэтгэлийг багтаасан улсын болон олон улсын хэмжлийн шаардлагад нийцсэн байна. Агуулахын удирдлагын системтэй холбогдоно. Ашиглагчийн данс бүртгэл ба тайлангийн систем нь хэмжилт ба удирдлагын төхөөрөмжөөр баталгаажиг гарна. Насос ба ачих байран дээр насосыг асаах/унтраах удирдлагыг байрлуулна.
Шүүлтүүр (тоолуурын өмнөх)	90м3/цаг нэвтрүүлэх чадалтай 6 ширхэг (удирдлагын системд мэдээлэл дамжуулагчтай, хувийн жин, зууралдлагад тохирсон, 0.15%-аас ихгүй нарийвчлалтай) 90м3/цаг нэвтрүүлэх чадалтай 6 ширхэг (API-1581 олон улсын стандартын шаардлага хангасан, тухайн бүтээгдэхүүний зориулалттай, ус ялгах, механик хольц шүүх шүүлтүүр байна)

Шатахууны насосууд:

Хүснэгт 3. Шатахууны насосуудын хүчин чадал

Вагонцистернээс буулгах/ачих насос	5ш	150м³/цаг (2500 л/мин)	1 x P-92 1 x ДТ 1 x ЕД 1 x Кер	Төвөөс зугтаах хүчний насос. 45кВт, 380В, 50Гц, фланецан холбогчтой, PN16, сорох өргөлт нь 5м, шахах өндөр нь 65м
Вагонцистернээс дээгүүр буулгах насос	1ш	75м³/цаг (1250 л/мин)	Дурын-1	Насос (Вагонцистернээс дээгүүр буулгах гартай холбогдох)
Автоцистернд ачих насос (босоо ба хэвтээ савуудаас)	5ш	75м³/цаг (1250 л/мин)	1 x P-92 1 x ДТ 1 x ЕД 2 x Кер	Төвөөс зугтаах хүчний насос. 15кВт, 380В, 50Гц, фланецан холбогчтой, PN16, сорох өргөлт нь 5м, шахах өндөр нь 32м
Автоцистернээс буулгах насос (хэвтээ сав руу)	1ш	150м³/цаг (1000 л/мин)	Дурын-1	Сэлүүрт-эргэлдэгч насос. 15кВт, 380В, 50Гц, фланецан холбогчтой, PN16, сорох өргөлт нь 4м, шахах өндөр нь 65м

Шатахууны хоолой: Вагонцистерны байгууламж ба насос станц хоорондын замыг хөндлөн гарах хэсэгт хоолойг газрын доор, гэр хоолойд байрлуулах бөгөөд бусад бүх хэсэгт хоолойг газар дээр байрлахаар төлөвлөнө. Хоолойн систем бүхлээрээ олон улсад мөрдөгддөг ган шугам хоолойн стандартын шаардлагад нийцсэн байна. Мөн хоолойн суурь материал нь нүүрстөрөгчит ган байна. Технологийн үндсэн шугам хоолой ба урт шугам хоолойнуудад ус, механик хольцийг шалгах болон суллах зорилгоор хамгийн доод түвшнээс нь авсан суллах хоолойг төлөвлөсөн байна. Хаалтаар тусгаарлагдсан хоолойн хэсэг бүр температурын зөрүүгээс үүсэх хэт даралтын нөлөөллөөс хамгаалж хоолойн хамгаалах клапан төлөвлөгдсөн байна.

Ослын байгууламжууд:

Шатахууны суллах сав нь 10м³ хэмжээтэй 5ш байх бөгөөд газар доор байрлаж, онцгой нөхцөлд шугам хоолойг бүрэн суллах зорилгоор хоолойнуудтай холбогдсон байна.

Ослын сав нь 10м^3 хэмжээтэй 1 ш бөгөөд автоцистернд ачих үед гэнэтийн ослын үед асгарсан шатахууныг цуглуулан авах зорилготой. Асгарсан шингэн хяналтгүй тархахаас сэргийлж ачих, буулгах, хадгалах болон насосын байгууламжуудад асгарсан бүтээгдэхүүн, бохирдсон усыг суваг, хоолойгоор цуглуулж худаг, сав ба ууршуулах талбай руу холбоно.

Бусад: Тус агуулах нь “Газрын тос. Газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Технологийн байгууламж. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5746:2007 Монгол улсын стандартын шаардлагуудыг хангасан.


2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төсөл хэрэгжих байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд нүүрсний газраас урагш 2.1 га талбайд байрлах ба тус газар нь Номин агуулахаас урагш 1.3 км, 4-р цахилгаан станцын үнсэн сангаас баруун урагш 700м, Дашваанжил хий цэнэглэх станцаас урагш 370м, Шинэ Эрийн ойл ХХК-ийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахын хойно 100 метрийн зайд үйлдвэрийн бүсэд байрлаж байна.



Зураг 2. Төслийн байршил



Зураг 3. Төслийн талбай, СХД-ийн хилээр



Зураг 4. Төслийн талбай, хорооны хилээр

2.2. Төслийн физик газарзүй

Төсөл хэрэгжих талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах бөгөөд Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн захын уулсын тойрогт хамрагдана.

Хэнтийн муж нь Монгол орны зүүн хойд хэсгийг хамрах ба баруун талаараа Туул, Орхон голын хөндийгөөр, зүүн талаараа Онон гол, зүүн урд талаараа Хэрлэн голын дунд бие хүртэл, өмнөд талаараа Туул голын урд тохойгоор зааглагддаг. Уулс нь өмнөд болон зүүн хэсгээрээ аажмаар намсаж цав толгодод шилждэг хэдий ч ерөнхийдөө уулархаг, өндрийн хэлбэлзэл 1500-2000 м хүрдэг. Эндэхийн уул зүйн үндсэн элементэд Хэнтийн гол нуруу түүний гол салбар болон захын уулс хамрагдана.

2.3. Цаг уур, уур амьсгал

Төсөл хэрэгжих бүс нутгийн цаг агаар, уур амьсгалын төлөв байдал, сарын дундаж үзүүлэлтийг тооцохын тулд цаг уурын хяналт шинжилгээний ажлын сүүлийн жилүүдийн агаарын температур, хур тунадас, салхины чиглэл, нарны тусгал зэргийн ажиглалтын мэдээг түүвэрлэн шугаман хандлагын хамаарлыг тооцон нөлөөллийн гол бүс нутаг Улаанбаатар хотын цаг агаарын жилийн болон хүйтний улирлын төлөв байдлыг тодорхойллоо.

Агаарын температур: Улаанбаатар хотын 2015-2025 оны хоорондох агаарын дундаж температурыг харьцуулахад, 2017 оны 7 дугаар сарын агаарын дундаж температур 21°C байсан бөгөөд бусад жилүүдийнхээс хамгийн дулаан, харин 2016

оны хүйтний улирлын буюу 1 дүгээр сарын агаарын дундаж температур -23.9°C тохиожээ. 2015-2025 оны бүх саруудад жигд дулаарал үүссэн байгаа нь дэлхийн дулаарал эрчимтэй явж буйг илэрхийлж байна.

Агаарын даралт: Улаанбаатар хотын агаарын даралт дунджаар 843 гПа байх ба голын хөндий орчмоор 865 гПа хүртэл хэлбэлзэнэ. Агаарын даралт жилийн турш тогтвортой, өөрчлөлт багатай 845-870 гПа орчим болдог. Агаарын даралтын сүүлийн сүүлийн 5 жилийн явцаас үзэхэд өвлийн сарууд болох 1, 12 саруудад хамгийн их утга, 7-р сард хамгийн бага утга 841-866 гПа тус тус ажиглагдсан байна. Төсөл хэрэгжих талбайн агаарын даралт 850 гПа байна.

Агаарын чийг: Улаанбаатар хотын жилийн дундаж харьцангуй чийгшил нь 50-60% хүрдэг бол хамгийн хуурай хаврын улиралд 45-55% байна. Энэ бүс нутагт хуурай өдөр 15-20 өдөр тохиолдож байхад 30-40 өдөр нь 80%-аас дээш чийгтэй байдаг. Зарим жилд өдрийн харьцангуй чийгшил 10%-аас доош орох тохиолдол гарч байсан байна.

Хур тунадас: Улаанбаатар хот орчмоор 2005-2025 оны хооронд хур тунадасны уналыг шугаман графикайн аргаар тооцоолон үзэхэд зуны 6, 7, 8 саруудад хур тунадасны хэмжээ хамгийн их байх ба 2012, 2015 онуудад хур тунадасны уналын хэмжээ жигд их байна. Улаанбаатар хот орчмын бүс нутагт жилд дунджаар 250-500 мм хур тунадас унадаг бол төслийн талбайд 300-400 мм хур тунадас унадаг байна.


Салхи: Улаанбаатар хот, Туул голын сав газрын салхи нь хойд, баруун хойд зүгийн салхи голлоно. Улаанбаатар хот тус орны салхи багатай газрын тоонд орно. Жилийн салхины дундаж хурд 4-6 м/с, салхины хамгийн их хурд нь 40 м/с хүрнэ. Жилд салхигүй өдрийн тоо 100 орчим байх бөгөөд салхины үнэмлэхүй их хурд нь V-IX сарын хооронд хамгийн их утга буюу 18-23 м/сек байна.

2.4. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хэнтийн муж 39-р тойрог буюу Хэнтийн захын тойрогт хамрагдаж байна.

Төсөл хэрэгжих талбайн хөрсний 80% нь техноген нөлөөнд өртсөн.


Төслийн талбайд аллювийн ширэгт хөрс зонхилон тархсан бол уулархаг хэсгээр хар хүрэн хөрс, голын хөндийгөөр аллювийн нугын сулавтар хөгжилтэй хөрс тархсан байна.



2.5. Гадаргын ус

Төслийн талбайтай хамгийн ойр орших гадаргын ус нь Туул гол бөгөөд төслийн талбайгаас урагш 1.4км-ийн зайд байрлаж байна.

Туул гол нь олон тооны гол горхи, булаг ихтэй бөгөөд Хэнтийн нурууны салбар уулсаас эх авсан Галттай, Хийд, Хаг, Зүүн баян, Тэрэлж, Улиастай, Сэлбэ зэрэг голууд цутгах ба харин голын уртын дагуугийн үлдэх ихэнх доод хэсэгт Түргэн, Харбух, Тосон зэрэг цөөн тооны жижиг гол горхиуд цутгана. Голын ус хурах талбай 49900 км², урт нь 874 км, ус хагалбарын шугамын урт 2055,6 км, ус хурах талбайн дундаж өндөр 1474 м, голдрилиын ерөнхий хэвгий 13% юм.




Зураг 6. Гадаргын ус

2.6. Ургамал бүрхэвч

Улаанбаатар хот нь Монгол орны бүс бүслүүрийн ангиллаар ойт хээрийн бүсэд хамрагдаж байна. Харин ургамал газарзүйн мужлалаар Хэнтийн уулын тайгын болон Монгол Дагуурын уулын ойт хээрийн гэсэн 2 тойргийн уулзвар нутагт байрладаг.

Төсөл хэрэгжих бүс нутагт олон жилийн өмнөөс үйлдвэр, аж ахуйн зориулалттай төслүүд олноор ажиллаж, барилга байгууламж барин техникийн болон хүний хөл хөдөлгөөнд дарагдсанаас үүдэн ургамал бүрхэвч нэлээдгүй өөрчлөгдөж, хөл газрын ургамлаар солигдсон. Харин төсөл хэрэгжих талбайн ургамал нь 95%-тай устсан, үлдсэн хувьд хөл газрын ургамал ургасан байна.

Төслийн талбайн ургамал бүрхэвч 5%, ургамлын дундаж өндөр 2-25см байв. Судалгаанд хамрагдсан хөрс, ургамал хурын усаар тэжээгддэг бөгөөд ургамлын хэв шинжийг Газар зохион байгуулалт, зураг зүйн газрын 2019 оны бэлчээрийн ургамлын зургийг ашиглан Arc Gis 10.8.12 программаар боловсруулахад Галофит өвст, Харгана-Хялганат болон бус сөөгөн бүлгэмдэл зонхилсон байна.



Таних тэмдэг

- Шинэ шанд ХХК
- Сонгинохайрхан дүүргийн хил

Ургамлын хэв шинж

- 17. Чулуусар алаг өс – Дааганоцүлт (*Koeleria macrantha*, *Poa attenuata*, *Stipa krylovii*, *Arenaria capillaris*, *Aster alpinus*)
- 22. Ботууль – Хялганат (*Stipa sareptana*, *S. krylovii*, *Festuca valesiaca*, *Psathyrostachys juncea*)
- 34. Хазаарөвст, Хялганат, Харганат (*Caragana bunge*,
- 38. Цагаан Шарилж –Хялганат, Таар –Хялганат
- 43. Сулыт (*Psammochloa villosa*, *Elymus racemosus*),
- 46. Харгана – Хялганат (*Stipa glareosa*, *S. gobica*,
- 139. Бут сөөг (*Salix kochiana*, *S. viminalis*), намгархаг шанага (*Carex dichroa*, *C. orbicularis*), үр тарианы нуга, зари газар шинэс
- 142. Галофит өвс (*Iris laevis*, *Halerpestes salsuginosa*), галофит өвс (*Achnatherum splendens*), судалгүй улаалж, зарим газарт булрац (*Salix ledebouriana*)

Зураг 7. Ургамлын хэв шинж, дүүргээр

2.7. Нийгэм эдийн засаг

Тухайн төслийн талбай нь Улаанбаатар хотын үйлдвэрийн бүсэд байрлах ба хамгийн ойр орших айл өрх нь 1.6км зайд байрлаж буй тул сөрөг нөлөө үзүүлэх нь ховор.

СХД нь бусад дүүрэгтэй харьцуулахад эдийн засгийн өсөлтийг хангах стратегийн ач холбогдол бүхий аж үйлдвэр, инновацийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих газар нутгийн нөөцтэй давуу талтай.

Түүнчлэн мах, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуйн фермерийг дэмжих бодлогыг Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөөнд тусгасан боловч энэ талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний цар хүрээ, үр дүн хязгаарлагдмал юм. Цаашид эрчимжсэн мал аж ахуйн фермерийг хөгжүүлэх, малын тэжээл, үр тариа, хүлэмжийн үйлдвэрлэл, хүнсний ногооны үйлдвэрлэлийн зориулалтаар газар олголтыг иргэн, аж ахуйн нэгжүүдэд оновчтой хуваарилах замаар эдийн засгийг тэлэх, төсвийн орлогын бааз сууриа өргөтгөх шаардлагатай.

Одоогоор СХД-ийг аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтын гол өсөлтийг хүнсний салбарын өсөлт хангаж байна. 2018 онд өмнөх оныхоос үйлдвэрлэлийн хэмжээ 57%-аар, борлуулалтын хэмжээ 40%-аар өссөн үзүүлэлттэй байна. Дүүргийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мах, загас, жимс ногоо, өөх тос боловсруулалт, үр тарианы гурил, малын тэжээлийн үйлдвэрлэл голлох байр суурийг эзэлдэг. Тус дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг өндөр болон дундаж орлоготой аж ахуйн нэгжүүд дүүргийн төсөвт орлого бүрдүүлдэггүй. СХД нь төсвийн татаас авдаг цөөхөн дүүргийн нэг учраас санхүүгийн хязгаарлагдмал нөөцийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн болон дүүрэгт шинээр бий болох бүтээн байгуулалт, аж үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ур чадвар ахиулах, давтан сургах түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай.

СХД-ийн нийт хүн ам 2018 оны эцсийн байдлаар 321.2 мянган хүн байгаагийн 38.4% нь ЭЗИХА, 33.6% нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2018 онд 48.1% байгаа нь Улаанбаатар хотын дундаж түвшингээс харьцангуй доогуур бөгөөд уг үзүүлэлтэд сүүлийн 7 жилийн хугацаанд огцом өөрчлөлт гараагүйг харуулна.

Ажилгүйдлийн түвшин 2018 оны байдлаар 9.9 хувь байгаа нь ажилгүйдлийн түвшин өндөртэй 3 дахь дүүрэг болж байна. СХД-т шилжилт хөдөлгөөн их, түр оршин суугч, хөдөө орон нутгийн хаягтай иргэд олон байгаа нь ажилгүйчүүдийн тоог нэмэгдүүлэх ба ХХҮХ-т ажлын байрын захиалга ирдэг боловч ажил хайгч иргэдийн ур чадвар, мэргэжлийн дадлага, туршлага нь захиалгад тохирдоггүй, иргэд тогтвортой ажиллах хүсэлгүй, ажлын байрны нөхцөл, цалин хөлсийг голдог, ажлын ачаалал даах чадваргүй, бэлэн халамж авах илүү сонирхолтой байдаг байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах”-ын үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэм эдийн засагт үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлоход дараах үр дүн гарч байна. Үүнд:

Агаарын чанарт:

1. Шатахууны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, ачих-буулгах ажиллагааны үед дэгдэмхий органик нэгдэл (VOC), нүүрсустөрөгчийн уур агаарт ялгарах
2. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт, утаа, азотын исэл (NO_x), нүүрсустөрөгчийн дутуу исэл (CO) зэрэг бохирдуулагч бодис агаарт ялгарах
3. Шатахуун асгарах, технологийн горим алдагдах үед нүүрсустөрөгчийн ууршилт нэмэгдэж орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх
4. Төслийн талбай нь аж үйлдвэрийн бүсэд байрладаг тул ойр орчмын үйлдвэр, тээврийн хэрэгсэл болон шороон замын хөдөлгөөнөөс үүсэх суурь агаарын бохирдол, тоосжилт төслийн орчны агаарын чанарт нөлөөлөх боломжтой.

Хөрсөн бүрхэвч:

1. Барилга байгууламжийн барилга угсралт, газар шорооны ажлын үед өнгөн хөрс хуулалт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон барилгын хатуу, шингэн хаягдлаас шалтгаалан хөрс эвдэрч, бохирдох
2. Газрын тосны бүтээгдэхүүний ачилт, буулгалт, тээвэрлэлт, хадгалалт, түгээлтийн явцад асгаралт, алдагдал үүссэнээр хөрс газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдох
3. Газрын тосны бүтээгдэхүүний тээвэрлэлтийн болон түгээлтийн үеийн автомашины хөдөлгөөнөөс хөрсний нягтрал нэмэгдэж, элэгдэл, эвдрэл үүсэх магадлалтай.
4. Ууршуулах талбайн ашиглалтын явцад газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдэл, асгаралтаас шалтгаалан хөрс бохирдож, хөрсний доройтол үүсэх эрсдэлтэй.

Ургамлан нөмрөг:

1. Барилга байгууламжийн барилга угсралт, газар шорооны ажлын үед барилгын болон ахуйн хаягдал, автомашины хөдөлгөөнөөс ургамлан бүрхэвч талхлагдаж, бохирдох.
2. Газрын тосны бүтээгдэхүүний ачилт, буулгалт, тээвэрлэлт, хадгалалтын явцад асгаралт, алдагдал гарсан тохиолдолд ургамлан бүрхэвч газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдох.
3. Тээврийн хэрэгслийн давтамжтай хөдөлгөөнөөс ургамлын бүрхэвч доройтож, ургамлын зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөгдөн хөл газрын ургамал давамгайлах.
4. Ууршуулах талбайн ашиглалтын үед ургамлан бүрхэвч бүрэн устаж, нөхөн сэргэх боломж буурах.

Усан орчин:

1. Төслийн талбайтай хамгийн ойр орших гадаргын ус нь Туул гол бөгөөд төслийн талбайгаас урагш 1.4 км-ийн зайд байрлаж байна. Иймд гадаргын усанд сөрөг нөлөөгүй.
2. Төслийн талбайн хойгуур 7-14 метр зайд зүүн хойноос баруун урагш чиглэлтэй ТЦБ-ын хаягдал ус урсан өнгөрөх ба үйлдвэрийн болон байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр далан халих аюултай.

Ажилчдын эрүүл мэнд аюулгүй байдал:

1. Төслийн талбай нь Улаанбаатар хотын үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд хамгийн ойр орших айл өрхөөс 1.6 км-ийн зайтай тул газрын тосны бүтээгдэхүүний агуулахын хэвийн үйл ажиллагаанаас оршин суугчдад үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл бага байна.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөөгүй тохиолдолд ажилтнууд болон ойр орчмын үйлдвэр, аж ахуйн нэгжийн ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.
3. Гал түймэр, дэлбэрэлт, газрын тосны бүтээгдэхүүн асгарах зэрэг осол, түүнчлэн байгалийн аюулт үзэгдэл, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй.
4. Осол, аваарын улмаас агуулахын үйл ажиллагаа түр зогсох, нийлүүлэлтийн тасалдал үүсэх, эд хөрөнгөд хохирол учрах, байгаль орчны бохирдол бий болох зэрэг нь ойр орчмын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж, эдийн засгийн шууд болон шууд бус хохирол учруулж болзошгүй.

**4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГОЛ ЗОРИЛТ**

Тухайн жилийн менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөлөл, өөрчлөлтүүдийг хянахад суурь материал болоход оршино.

Хүснэгт 4. 2026 оны БОМТ-ний нийт зардал

№	Төлөвлөлт	БОМТ зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	600,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,319,500
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	850,000
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,200,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,698,000
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	6,600,000
7	БОМТ хэлэлцэх хуваарь	600,000
НИЙТ		12,867,500

5. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 5. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	2026 оны төсөв, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанарыг хамгаалах					
1	Тээврийн хэрэгсэл болон газрын тосны бүтээгдэхүүний үйл ажиллагаанаас тоосжилт, ууршилт үүсэх	Технологийн байгууламжийн битүүмжлэл, клапан, дамжуулах шугамын хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавих	Үйл ажиллагааны зардалд	Байнгын	Агаарын тухай хууль, MNS 4585:2025, MNS 5746:2007
Газрын гадаргыг хамгаалах					
2	Автомашин хөдөлгөөнөөс газрын гадарга талхлагдах	Автомашин хөдөлгөөнийг зөвхөн тогтоосон маршрутаар явуулж, шороон замын засвар, арчилгааг тогтмол хийх	300,000	Жилийн турш	MNS 5914:2023
Хөрсөн бүрхэвчийг хамгаалах					
3	Хурын ус хуримтлагдсанаас хөрс бохирдох, технологийн байгууламжийн хэвийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөх	Ус зайлуулах суваг, шуудууг тогтмол цэвэрлэж, нөөцийн савны орчны ус зайлуулах системийн хэвийн ажиллагааг хангах	300,000	Жилийн турш	MNS 5746:2007, MNS 5850:2019
Гадаргын болон газрын доорх усыг хамгаалах					
4	Газрын тосны бүтээгдэхүүний алдагдлаас ус бохирдох эрсдэл	Технологийн байгууламжийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, алдагдал гарсан тохиолдолд шуурхай засварлах	Үйл ажиллагааны зардалд	Байнгын	Усны тухай хууль, MNS 0900:2018
Ургамлан бүрхэвчийг хамгаалах					
5	Автомашин хөдөлгөөн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвч доройтох	Ногоон байгууламжийг арчилж хамгаалах, эвдэрсэн хэсгийг нөхөн тарьж, арчилгаа хийх	Үйл ажиллагааны зардалд	Ургалтын хугацаанд	MNS 5918:2023, MNS 6260:2011
НИЙТ			600,000		

5.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Орчны тохижилт хийх төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хугацаа	Баримтлах стандарт
1	Талбайн өнгө үзэмж, ажилтны тав тухтай орчин бүрдүүлэх	Мандлын цэцэг тарих, зүлэгжүүлэх талбайг нөхөн сэргээх	Ажилчдын байр орчим, ногоон байгууламж	багц	1	176,000	176,000	V–VI сар	MNS 5918:2023, MNS 6260:2011
2	Ургамлын дэмжих ургалтыг	Гумины бордоо, биолзмаг, ургамлын ургалт дэмжих бүтээгдэхүүн хэрэглэх	Ногоон байгууламж	багц	1	56,000	56,000	V–VII сар	MNS 5918:2023
3	Тэрбум модны хүрээнд дүйцүүлэх байдлаар мод тарих	Хайлаас, улиас, шар хуайс, буйлс зэрэг мод, бут тарих	СХД-ийн 20-р хорооны цэцэрлэгт хүрээлэн	багц	1	587,500	587,500	V болон X сар	MNS 5918:2023, MNS 6260:2011
4	Тарьсан ургамлын арчилгаа	Усалгаа, хог ургамал цэвэрлэгээ, арчилгаа хийх	Ногоон байгууламж	багц	1	500,000	500,000	Ургалтын хугацаанд	MNS 6260:2011
НИЙТ							1,319,500		

5.3. Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Галын аюултай шатамхай шингэн хадгалж байгаа тул гал гарах, тэсэрч дэлбэрэх эрсдэлтэй	Галын болон техникийн аюулгүй ажиллагааны заавар, болзошгүй аваар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг мөрдөж ажиллах	Төслийн нийт талбай	удаа	-	-	-	Жилийн турш	Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, MNS 4244:1994
2	Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүйгээс осол, эрсдэл нэмэгдэх	Галын аюулгүй байдал болон газрын тосны бүтээгдэхүүний хор, аюулыг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ, санамжийг байрлуулах, шинэчлэх	Технологийн байгууламж, агуулахын бүс	багц	500,000	1	500,000	I улирал	MNS 5566:2005, MNS 4244:1994
3	Гал хэрэгслийн унтраах бүрэн байдал алдагдсанаас ослын үед хариу арга хэмжээ авах боломж буурах	Гал унтраах хөөс, галын хор, хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдал, бэлэн байдлыг хангах	Галын аюултай байгууламж	багц	-	-	Үйл ажиллагааны зардалд	Жилийн турш	Галын аюулгүй байдлын тухай хууль, MNS 5566:2005
4	Галын усан сан ажиллахгүй байх, усны эх үүсвэр хангалтгүй байх	Галын усан сан, усан хангамжийн бэлэн байдлыг хангах	Галын усан сан	удаа	-	-	Үйл ажиллагааны зардалд	Жилийн турш	Галын аюулгүй байдлын тухай хууль
5	Ажилчдын мэдлэг, мэдээлэл дутуугаас осол, аваар гарах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, галын аюулгүй байдал, анхан шатны тусламжийн сургалт зохион байгуулах	Нийт ажилтнууд	сургалт	200,000	1	200,000	I, III улирал	ХАБЭА-н тухай хууль, MNS 4990:2000, MNS 4967:2000
6	Ослын үед анхан шатны тусламж үзүүлэх боломж хангалтгүй байх	Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг шинэчлэн бүрдүүлж, бэлэн байлгах	Анхны тусламжийн цэг	багц	150,000	1	150,000	I улирал	Ажлын байранд анхан шатны тусламж үзүүлэх заавар
		НИЙТ					850,000		

5.4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг зөвшөөрөл бүхий хог хаягдлын төвлөрсөн цэгт тогтмол хүргүүлж устгах	Төслийн талбай	удаа	100,000	12	1,200,000	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль, Хог хаягдлын менежментийн холбогдох журам
2	Ахуйн болон технологийн хаягдал	Хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах, зориулалтын саванд цуглуулах	Төслийн талбай	багц	Үйл ажиллагааны зардалд	-	-	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
3	Технологийн хаягдал	Ууршуулах талбай болон цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг тогтмол хянаж, засвар үйлчилгээ хийх	Төслийн талбай	багц	Үйл ажиллагааны зардалд	-	-	Жилийн турш	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Хог хаягдлын тухай хууль
НИЙТ							1,200,000		

5.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

ОХШХ-ийн хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжих нөлөөллийн бүс түүний орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах, сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

Хагас жил бүр орчны хяналт, шинжилгээний үзүүлэлтийг анхааралтай судалж өөрчлөлтийн үндсэн шалтгааныг тодорхойлон цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт амьдардаг иргэдийг аливаа сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй, тодорхой болгоход ашиглах шаардлагатай юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ байнгын 5 цэг сонгосон бөгөөд хөрсний мониторингийн 3 цэг, усны мониторингийн 1 цэг, агаарын 1 цэг сонголоо.

Хүснэгт 9. ОХШ-ний дээж авах тогтмол цэг

№	Дээжийн нэр	Дээжийн байршил	Мониторингийн цэгийн байршил	
			Х	У
Хөрсний мониторинг цэг				
1	Дээж-1	Агуулахын байгууламжийн дэргэд	Координатын байршил одоогоор тодорхойгүй	
2	Дээж-2	Ууршуулах талбайн дэргэд		
3	Дээж-3	Цэвэрлэх байгууламжийн дэргэд		
Усны мониторинг цэг				
4	Дээж-1	Гүний худаг	Координатын байршил одоогоор тодорхойгүй	
Агаарын чанарын мониторинг цэг				
5	Дээж-1	Үйлдвэрийн дотоод орчин		

**“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” төслийн
2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Хүснэгт 10. ОХШХ

	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын н цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нэг жилийн зардал, төг	Тайлбар	Баримлах эрзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанарыг хянах	Хүхэрлэг хий, азотын давхар исэл, Тоосжилт, Дуу чимээ	1	6-р сар	1	60,000	60,000	Лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэнэ	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”
Усны чанарыг хянах	Ерөнхий шинжилгээ	1	6, 9-р сар	2	50,000	100,000		Усны чанар: Дээжлэлт – Дээж хадгалах, тээвэрлэх журам MNS (ISO) 4867:1999
	Хүнд металл				30,000	60,000		
	Микробиологи	1			100,000	200,000		MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Хөрсний бохирдлыг хянах	Агрохими	3	6, 9-р сар	2	28,000	168,000		MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металл				35,000	210,000		
	Микробиологи				150,000	900,000		
Ургамал нөмрөг	Хээрийн ажиглалт	Төслийн талбайд	6-р сарын сүүл	1	Сөрөг нөлөөлөл бууруулах зөвлөмжид тусгав		Байгалийн ургамлын тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль MNS 5918:2023	
НИЙТ ЗАРДАЛ						1,698,000		

5.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардлын төсөв, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцсан мэргэжилтэн	Баримтлах стандарт, аргачлал
1	Ажилчдыг тогтмол хор тайлах бүтээгдэхүүнээр хангахаас гадна жил бүр эмнэлгийн 3 шатны үзлэгт хамруулж, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	600,000	Оны эхэнд	Менежер, ХАБ хариуцсан мэргэжилтэн	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журам Болзошгүй осол аваарын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
2	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	3,000,000	2026 оны эхэнд	Менежер, ХАБ хариуцсан мэргэжилтэн	Байгаль хамгаалах тухай хууль
3	ТЖБОМТ-г өмнөх оны 12-р сард багтаан БОАЖЯ-аар батлуулж, уг ТЖБОМТ-нд тусгасан төлөвлөгөөт ажлуудаа тухайн ондоо хийж гүйцэтгэсний дараа биелэлтийн тайланг боловсруулан 11-р сард багтаан орон нутгаас томилогдсон ажлын хэсгээр холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд нь дүгнүүлэх	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Оны турш	Менежер, ХАБ хариуцсан мэргэжилтэн	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент- тийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
НИЙТ		6,600.0			

5.7. Тухайн жилийн БОМТ-ийн хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 12. БОМТ тайлагнах хуваарь

Байгууллага	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Зардал, төг
Нийслэлийн Байгаль орчны газар	Жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг албан бичгээр хүргүүлэх	БОМТ-ийн хэрэгжилт, орчны хяналт-шинжилгээ, мониторингийн үр дүн	Жил бүрийн IV улирал	БОМТ-ийн хэрэгжилтийг хянах, дараагийн жилийн төлөвлөгөөг сайжруулах санал	Нийслэлийн Байгаль орчны газар	300,000
Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар	БОМТ-ийн хэрэгжилтийн талаар албан мэдээлэл хүргүүлэх	Төслийн хэрэгжилт, байгаль орчны хамгааллын арга хэмжээ	Жил бүрийн IV улирал	Байгаль орчны асуудлаар санал авах	Сонгинохайрхан дүүрэг	200,000
Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо	Иргэдэд мэдээлэл хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд уулзалт зохион байгуулах	БОМТ-ийн хэрэгжилт, байгаль орчны хамгаалалтын арга хэмжээ, иргэдийн санал хүсэлт	Жил бүрийн IV улирал	Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч БОМТ-д тусгах	20 дугаар хорооны байр	100,000
НИЙТ						600,000

ХАВСРАЛТ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000192635

2017.11.27
/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011709069
/ Хувийн хэргийн дугаар /

6252281
/ Регистрийн дугаар /

Шинэ шанд Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр 01 2017.11.24
/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

4610 Гадаад худалдаа
/ Код / / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 2 330,020.00
/ хугацаа / / гишүүдийн тоо / / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол, 4-р хороо, голден парк, энх тайвны өргөн чөлөө, 104, 166 тоот, Утас1:
99991114, Утас2: 99114361, Факс:
/ хуулийн этгээдийн илбан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 10 сар 23 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл			
Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Батөлзий овогтой Одмаа-г Гүйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв.	2019.10.23	Г.Алтай
2	Дахин гэрчилгээ олгов.	2019.10.23	Г.Алтай
3	Улаанбаатар, Баянгол, 4-р хороо, голдөн парк, энх тайвны өргөн чөлөө, 104, 166 тоот Утас1: 99114361, Утас2: 89066806, Факс: хялгийг шинээр бүртгэв.	2020.06.15	С.Цолмон
4	Хувьцаа эзэмшигч 0 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.06.15	С.Цолмон
5	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2020.06.15	С.Цолмон
6	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2024.12.06	Х.Бүрээдбаатар
7	Цэнгэмаа овогтой Амраа-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2024.12.06	Х.Бүрээдбаатар
8	Эцсийн өмчлөгч 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2024.12.06	Х.Бүрээдбаатар

Энэхүү гэрчилгээг хуурамчээр үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцахаг хүтээснэг.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

* 0 0 0 1 9 2 6 3 5 *

2. Газрын гэрчилгээ, кадастр


			
МОНГОЛ УЛС			
АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН			
ГЭРЧИЛГЭЭ			
Дугаар: 0000285033			
Шинэ шанд ХХК		6252281	
(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)		(регистрийн дугаар)	
Нийслэлийн Засаг даргын захирамж 20 24 оны 05 сарын 03 өдрийн А/500 тоот			
(шийдвэр гаргагч)			
Шийдвэрийг үндэслэн	Улаанбаатар	Сонгинохайрхан	20-р хороо
	(аймаг, нийслэл)	(сум, дүүрэг)	(баг, хороо)
Нүүрсний газраас урагш			хаягт
(гудамжны нэр)			(хашааны дугаар)
байрлах, нэгж талбарын	1801501007	дугаар бүхий	21406 м.кв газрыг
Агуулах, агуулахын байгууламж			зориулалтаар
15	жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн		Э-2201006957
дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.			
			
Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.			
Хэвлэсэн огноо: 2025-01-21			

Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба

Нэгж талбарын дугаар: 1801501007 Эрхийн төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 6252281 Хуулийн этгээдийн нэр: Шинэ шанд

ХАЯГ:	Аймаг/Хот: Улаанбаатар	Сум/Дүүрэг: Сонгинохайрхан	Баг/Хороо: 20-р хороо	Кадастрын муж: 8015
	ШИНЭ: Гудамж: Нүүрсний газраас урагш	Тоот:	ХУУЧИН: Гудамж/Нүүрсний газраас урагш	Тоот:




Хэвлэсэн огноо: 2024-08-06

Зургийн масштаб = 1:1543 (1 сантиметрт 15.43 метр багтана)

Координатын систем:
WGS84/UTM 48N
EPSG: 32648

Орчны тойм



Масштаб = 1: 27084

Талбайн хэмжээ: 21406 квадрат метр



Энэхүү кадастрын зураг нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

www.egazag.gov.mn

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” төслийн
2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ТӨЛӨВЛӨЛТИЙН САНАА

ЗАХИАЛГАЧИЙН ХҮСЭЛТ :

- Ачих төхөөрөмж, саравч 27.5х10.0м
- Босоо цилиндр ил сав 2000м3-2ш
- Босоо цилиндр ил сав 3000м3-2ш
- Ууршуулах талбай
- Насос станц
- Хэтгээ ил сав 2ш

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН СУДАЛГАА :

- Газрын тосны бүтээгдэхүүн агуулах, хадгалах зориулалттай 2000м3-ийн 2ш, 3000м3-ийн 2ш ил босоо цилиндр сав.
- Ачих төхөөрөмж, саравч
- Харуулын байр 3х3м, 2ш
- Галын усан сан 500м3
- Авто машины зам талбай
- Галын сарай
- Аянга зайлуулагч

ГРАФИК ЗУРАГЛАЛ :



Сонгинохайрхан дүүрэг 20-р хороонд баригдах “Шинэ шанд” ХХК-ийн Газрын тосны бүтээгдэхүүний агуулах “Эм Пи Ай консалтант” ХХК-ийн ЗТА-ын захирал	Нэр	Гарын үсэг	Зөвхөр
Архитектор	М.Намуундэвч		Хуудас 03
Захиалагч : “Шинэ шанд” ХХК-ийн захирал	Б.Ормал		2024 он

НИЙСЛЭЛ ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БАТЛАВ:

ХЯНАСАН:

- Хот байгуулалт, хотын стандартын газрын
- Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Хот байгуулалт, хотын стандартын газрын
- Хот байгуулалт харууцсан мэргэжилтэн

/ Ч.Төгсдэлгэр /


/ Б.Батцогмон /

/ В.Нүрэд /

ҮНДЭСЛЭЛ

- Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05-р сарын 03-ны А/500 тоот дугаар захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт, Сонголон-6 (18135) бүсчлэлд, У-3 нэгж хороололд “Шинэ эрин ойл” ХХК-ийн хойд талд “Агуулах агуулахын байгууламж” зориулалтаар эзэмшүүлсэн 1801501007 нэгж талбарын дугаартай 2.14 га газар олгов.
- “Эс Эс Маке” ХХК-ийн 2018 оны 12-р сард боловсруулсан дэвсгэр зураг
- “Шинэ шанд” ХХК-ийн боловсруулсан ажлын зургийн даалгавар.
- Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын нөхцөл байдлыг 30.01.04-ийн ... зүйлийн үндсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг гүйцэтгэв.
- ХБХТ-ын 2024 оны 09 сарын 30 өдрийн 2024/00-654 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэв.

ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ М1:1000



ТОДОРХОЙЛОЛТ

№	Тодорхойлолт	Талбай
1	Оффисийн барилга 24.0х12.0м	Төлөвлөх буй
2	Насос станц 12.0х21.0м	Төлөвлөх буй
3	2000м3-3ш багтаамжтай босоо цилиндр ил сав	Төлөвлөх буй
4	3000м3-2ш багтаамжтай босоо цилиндр ил сав	Төлөвлөх буй
5	10м3 хэтгээ цилиндр сулгах сав 5ш	Төлөвлөх буй
6	Галын усан сан 500м3	Төлөвлөх буй
7	Галын хана	Төлөвлөх буй
8	Ачаа шалгах шат тавцан	Төлөвлөх буй
9	Автоцистернд ачих төхөөрөмжийн шат тавцан, саравч	Төлөвлөх буй
10	10 байраар вагонцистернээс шатахуун буулгах төхөөрөмж, үүсгүүр шат тавцан эсвэл	Төлөвлөх буй
11	Автоцистернд ачих төхөөрөмжийн бетон талбай	Төлөвлөх буй
12	Автоцистернээс шатахуун буулгах бетон талбай	Төлөвлөх буй
13	Ачаа шалгах бетон талбай	Төлөвлөх буй
14	Сав паркийн бетон талбай	Төлөвлөх буй
15	Авто машины жолоогчийн зам талбай	Төлөвлөх буй
16	Галын автомашин, техник хэрэгсэлийн зам талбай	Төлөвлөх буй
17	Хайргын зам талбай	Төлөвлөх буй
18	Яаган хуний зам талбай	Төлөвлөх буй
19	Аянга хамгаалагч 2ш	Төлөвлөх буй
20	Гэрэлтүүлгийн цамхаг 2ш	Төлөвлөх буй
21	Галын бажааны сарай 2ш	Төлөвлөх буй
22	Автоцистернээс шатахуун буулгах худал	Төлөвлөх буй
23	Ууршуулах талбай	Төлөвлөх буй
24	Дизель цахилгаан үүсгүүрийн байр	Төлөвлөх буй
25	Харуулын байр 3.0х3.0м, 2ш	Төлөвлөх буй
26	Боомрын цооног	Төлөвлөх буй
27	Хаалга	Төлөвлөх буй
28	Авто зогсоол	Төлөвлөх буй

БАЙРШЛЫН СХЕМ



ТАНИХ ТЭМДЭГЛЭГЭЭ

Төлөвлөх буй барилга, байгууламж	Төлөвлөх буй төмөр бетон талбай
Төлөвлөх буй авто зам	Төлөвлөх буй хайргын зам талбай
Төлөвлөх буй яаган хуний зам	Болов усны шугам
Төлөвлөх буй могоон байгууламж	Дулааны шугам
Эзэмшил газрын хил хязгар	Цэвэр усны шугам
Архитектур төлөвлөлтийн дэлгэрэнгүй ойлголт	Цахилгааны шугам
Төлөвлөх буй галын авто машины зам талбай	

Барилгажилтын үзүүлэлт:

	5	7	ДТХ-ны 2.1, ББХ-ны 0.4 үзүүлэлтийг баримтлав.	2ш
1 Газар доорх сав	5	7 Галын гарц, аврах гарцын тоо	Машин ш%	1ш, 0.15%
2 Газар доорх усан сан	10	8 Рамп, пандусын тоо	ХБИ ш%	1ш, 0.15%
3 Ил авто зогсоол	5	9 Сэргээгдэх эрчим хүч		
4 Газар доорх авто зогсоол	-	10 Шинэ, шилдэг технологи		
5 Шатахуун буулгах талбай	2	11 Архитектурын хэв маяг		
6 ХБИ-ийн авто зогсоол	1			



Сонгинохайрхан дүүрэг 20-р хороонд баригдах “Шинэ шанд” ХХК-ийн Газрын тосны бүтээгдэхүүний агуулах “Эм Пи Ай консалтант” ХХК-ийн ЗТА-ын захирал	Нэр	Гарын үсэг	Зөвхөр
Архитектор	М.Намуундэвч		Хуудас 06
Захиалагч : “Шинэ шанд” ХХК-ийн захирал	Б.Ормал		2024 он

4. БОННУ, 5 жилийн БОМТ-ний баталгаажих нүүр

БАТЛАВ:
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Ч. ХАНДСҮРЭН

ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

3. ЦОГТБАЯР

ШИНЭ ШАНД ХХК-НИЙ ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ -ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН ДУГААР:
5323576



ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:
"ХАТАН ДАЛАЙ" ХХК

Нэр: Гарын үсэг:

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ШИНЭ ШАНД ХХК

Нэр: Гарын үсэг:

2025 ОН

